

# 蒙古时文选读

第三册

李宪民 编

中国人民解放军外国语学院一系第五教研室

一九九七年一月

## ГАРЧИГ

|      |                            |     |
|------|----------------------------|-----|
| 10-Р | ХИЧЭЭЛ                     |     |
|      | ЯЛАЛТЫН 50 ЖИЛИЙН ОЙД----- | 1   |
| 11-Р | ХИЧЭЭЛ                     |     |
|      | НУБ---50-----              | 47  |
| 12-Р | ХИЧЭЭЛ                     |     |
|      | 1995 ОН-СОЁЛЫН ЖИЛ-----    | 89  |
| 13-Р | ХИЧЭЭЛ                     |     |
|      | УРАН САЙХАНЧИД-----        | 126 |
| 14-Р | ХИЧЭЭЛ                     |     |
|      | БОЛОВСРОЛЫН ЖИЛ-----       | 156 |

10-р ХИЧЭЭЛ  
ЯЛСАЛТЫН 50 ЖИЛИЙОН ОЙД

Сросын Холбооны Улсын Ерөнхийлөгч  
эрхэмсэг ноён Борис Николаевич  
Ельцэн танаа Москва, Кремль

Монголын ард түмний өмнөөс болон хувиасаа Танд, нийрамдалт оросын ард түмэнд фашизмыг ялсны 50 жилийн оиг тохиолдццлан чин сэтгэлийн баяр хүргэж, Сайн Сайхан бүхнийг хүсэн ерөө.

Фашизмыг бут ниргэсэн аугаа их ялалт нь дэлхийн улс түмний эрх чөлөө, ардчилал, дэвшлийн төлөө эрхэм дээд эрмэлзэл, хүний нэр тэр, аж төрөх эрхээ өмгөөлөн хамгаалахад нэгэн үзүүрт зориг санаатай байдгийг харуулснаараа дэлхий ХХ зууны түүхэн дэх хамгийн гайхамшигт үйл явдал болсон юм.

Дайнд үрагдэгсэд болон үлдэгсдийн гагзаан дурсгалын энэ өдөр хотол дэлхийн энх тайван, амьдралын төлөө тэмцэлд түмэн зөвлөн, өнчрөл хагацлын бэрхийрч гарсан зөвлөлтийн хүмүүсийн мятаршгүй эх оронч үзэл, эр зоригийг бид гүнзээ мэхийн хүндэтгэж байна.

Энхийн үйлс, холбоотны үүрэгтээ үнэнч монголимн ард түмэн Зөвлөлт Холбоот Улс, гитлерийн эсрэг бүх эвслийн талд баттай зогсож, фашизмын боолчлооос згнагт ангижрахын төлөө нийтийн тэмцэлд хэр

чинээний хувь нэмрээ оруулсан билээ.

Фашизмыг ялсны 50 жилийн ойн энэ өдөр Оросын Холбоосны Улсын ард түмэнд хөгжил цэцэглэл, Танр болон бүх ахмад дайчдад зол жаргал сайн сайхн эрээл дэвшүүлье.

Монгол Улсын Ерөнхийлөгч  
Пүнсалмаагийн ОЧИРБАТ

Улаанбаатар хот,  
1995 оны тавдугаар сарын 6

### 2. Москва орохоор мордлоо

Монгол Улсын Ерөнхийлөгч П. Очирбат дагалдаач яваа хүмүүсийнхээ хамт ялалтын 50 жилийн ойн баярт оролцохоор Москва хот руу мордлоо. Ерөнхийлөгчийг Буянг-Ухаагийн нисэх онгоцны буудлаас Монгол Улсын Ерөнхий сайд П. Жасрай, Улсын Их Хурлын дэд дарга Ж. Гомбожав. Дэд бүтцийн хөгжлийн сайд Р. Сандалхан, Гадаад харилцааны дэд сайд Ж. Чойнхор, Үатлан хамгаалахын дэд сайд Ц. Дашэзвэг, Зэвсагт хүчний ерөнхий штабын дарга Р. Гаваа, ОХУ-аас манай улсад суугаа Онц бөгөөд Бүрэн хрхт элчин сайд С. С. Рязов нар болон албаны бусад хүн удлээ.

### 3. Москвад хүрэлцэн ирэв

Ерөнхийлөгч П. Очирбат ялалтын 50 жилийн сийн баярт оролцооор тавдугаар сарын 7-нд Москва хотноос хүрэлцэн ирэв.

"Шереметьево-11" нисэх онгоцны буудал дээр Монгол Улсын Ерөнхийлөгч П. Очирбатыг ОХУ-ын Онц байдлын яамны сайд С. К. Шойгу, Гадаад хэргийн орлогч сайд П. Н. Панов, албаны бусад хүн угтлаг.

Мөн Монгол Улсаас д суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайд Н. Бавуу, элчин сайдын яамны дипломат ажилтнууд байлцав.

Монгол Улсын Ерөнхийлөгч П. Очирбат Москва ирэх замдаа Новосибирск хотод түр буудаллахад тус хотын орлогч дарга В. П. Некорошков угтан уулзаж ярилцсан байна.

Гадаад харилцааны яамны хэвлэл  
мэдээлийн алба

4. П. Очирбатад бараалхав  
ОХУ-ын Засгийн газрын орлогч дарга, Монгол, Оросын Засгийн газар зоорондын комиссын оросын хэсгийн дарга А. Х. Заверюха ялалтын 50 жилийн ойн баяр ёслолд оролцож байгаа Монгол Улсын Ерөнхийлөгч П. Очирбатад энэ тавдугаар сарын 8-нд бараалхав. Уулзалтын үеэр хоёр орны харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх талаар урьд тохиролцсон арга хэмжээнүүдийг ажил хэрэг болгох асуудлаар санал солилцов. Уулзалтад Ерөнхийлөгчийн

Тамгын газрын дарга М. Энхсайхан, Элчин сайд Н. Бавуу, ОХУ-ын ГЯЯ-ны Азийн газрын монголын хэлтсийн дарга В. Н. Шетинин нар байлцав.

5. Хөшөөний нээлтэд оролцоэ, цэцэг өргөв  
Ялалтын 50 жилийн ойн баярт оролцож байгаа  
Монгол Улсын Ерөнхийлөгч П. Очирбат тэргүүтэй  
төлөөлөгчид Москва хотын Манежийн талбай дахь  
маршал Г. К. Жуковын хөшөөг нээх ёслолд тавдугаар  
сарын 8-нд оролцлоо. Хөшөөг нээх ёслол дээр Москва  
хотын дарга Юрий Лужков хэлсэн үгэндээ, маршал Г.  
К. Жуковын хөшөөнд Оросын баатруудын гайхамшигт  
оролхаг зориг, хүч чадлыг уран чадварлаг илэрхийлж  
харуулсныг онцлон тэмдэглэв.

Хөшөөний нээлтийн ёслол дээр Монгол Улсын  
Ерөнхийлөгч П. Очирбат тэргүүтэй төлөөлөгчид цэцэг  
өргөлөө. Цэцгийн туузан дээр "ЗХУ-ын дөрвөн  
удаагийн баатар, Монгол Улсын баатар, цэргийн  
гарамгай жанжин Георгий Константинович Жуков агсын  
гэгээн дурсгалд. Монгол Улсын Ерөнхийлөгч П.  
Очирбат. 1995.05.08" гэж бичжээ.

Мөн өдөр Ерөнхийлөгч П. Очирбат тэргүүтэй  
төлөөлөгчид Александровын цэцэрлэг дэх Нэр нь  
тодроогүй цэргийн булшинд цэцэг өргөв. Цэцгийн  
туузан дээр "Хүн төрөлхтний эрх чөлөө, аз заргалын  
төлөө баатарлагаар тулалдаж амь эрсэдсан нэр нь  
тодроогүй дайчдын дурсгалд. Монгол Улсын

Бренхийлөгч П. Очирбат, 1995.05.08" гэжээ. Цэцэг  
өргөх ёслолын үеэр Оросын цэргийн хүндэт харуул  
жагсаж, хөгжим эгшиглэв.

#### 6. Ялалтын ойн хуралд оролцов

Аугаа их эх орны дайнд ялалт байгуулсны 50  
жилийн ойн баярт зориулсан баярын хурал, концерт  
тавдугаар сарын 8-нд Кремлийн ордонд болов. Баярын  
хуралд гадаадын төр, засгийн тэргүүн, зочид  
түүний дотор Монгол Улсын Ерөнхийлөгч П. Очирбат  
тэргүүтэй төлөөлөгчид оролцож, баярын концерт үзэв.

Монгол Улсын Ерөнхийлөгч. П. Очирбат тэргүүтэй  
төлөөлөгчид тавдугаар сарын 9-нд Москва хотын  
Улаан талбайд болсон аугаа их эх орны дайнд  
оролцогсад, ар талд ажиллаж байсан ахмадуудын  
жагсаал үзэв. Энэ үеэр П. Очирбат АНУ-ын  
Ерөнхийлөгч Б. Клинтон, Канад Улсын Ерөнхий сайд  
Ж. Кретъен, БНХАУ-ын дарга Зян Зэминь зэрэг  
гадаадын зочидтой уулзаж мэндчилэв.

#### 7. Дайллагын үеэр найрсгаар ярилцжээ

Ялалтын 50 жилийн ойд зориулж ОХУ-ын  
Ерөнхийлөгч Б. Н. Ельцин Кремлийн ордонд тавдугаар  
сарын 9-нд дайллага хийв. Дайллагад ОХУ-ын төр,  
засаг, парламентын удирдагчид, гишүүд, ахмад

дайчид, зүтгэлнүүд, гадаад орнуудын төр, засгийн тэргүүн, төлөөлөгчдийн гишүүд оролцлоо. Дайллагын үеэр Монгол Улсын Ерөнхийлөгч П. Очирбат, ОХУ-ын Ерөнхийлөгч Б. Н. Ельцин нар уулзаж найрсгаар ярилцав.

8. Цэргийн жагсаал,  
дурсгалын цогцолбор үзэв

Монгол Улсын Ерөнхийлөгч П. Очирбат тэргүүтэй төлөөлөгчид тавдугаар сарын 9-нд ялалтын 50 жилийн ойн баярт зориулан Хүндэтгэлийн ууланд болсон цэргийн жагсаалыг үзэв. Дараа нь аугаа эх орны дайчид ялалтад зориулсан дурсгалын цогцолбор музейн нээлтэд оролцлоо.

Монгол Улсын Ерөнхийлөгч П. Очирбат тэргүүтэй төлөөлөгчид музейн "Яруу алдар", "Дурсамж" танхimuудаар орж, үзмэрүүдийг сонирхон үзэж, хүндэт зочдын номд сэтгэгдлээ бичиж үлдээв.

Түүнд "Эх орны их дайны төв музейг сэтгэл догдлон үзлээ. Дэлхийн хоёрдугаар дайны жилүүдэд завлалтийн ард түмэн, түүний ялгуусан арми фашизмын эсрэг хийсэн ширүүн тэмцэлд гайхамшигт ялалт байгуулсны тус музейн үзмэрт яруу тодоор харуулжээ.

Хүн төрөлхтөн дайн дажингүй энх тунх 50 жил болж байгаа нь энэхүү ялалтын түүхэн гавьяа билээ.

Монгол Улсын Ерөнхийлөгч П. Очирбат" гэж бичжээ.

### 9. Жанжны нэрэмжит танкийн хороонд зочлов

Ялалтын 50 жилийн ойн баярт оролцсон Монгол Улсын Ерөнхийлөгч П. Очирбат тэргүүтэй төлөөлөгчид Владимир дахь Д. Сүхбаатарын нэрэмжит танкийн сургуулийн 44 дүгээр хороонд тавдугаар сарын 10-ны өдөр зочлов.

Монгол Улсын Ерөнхийлөгч П. Очирбат тэргүүтэй төлөөлөгчдийг тус хороонд очиход орос ардын уламжлалт ёсоор талх, давс барин мэндчилж, хүндэт хөрүүл жагсан хоёр орны сүлд дуулал хөгжимд эгниглэв.

Ерөнхийлөгч П. Очарбат тус хорооны ахмад дайчидтай уулдаан, баярын мэнд дэвшүүлээд төлөөлөгчдийн хамт дайчин замналын музей үзлээ.

Музейн хүндэт зочны номонд "Д. Сүхбаатарын нэрэмжит танкийн сургуулийн 44 дүгээр хороосны офицер, ахлагч цэргүүд, бүх бие бүрэлдэхүүнд Аугах их эх орны дайны ялалтын 50 жилийн ойн баярын мэнд хүргэж, сайн сайхан, аз жаргал, амжилт бүтээлийн дээдийг хүсэн ерөө 1 Монгол Улсын Ерөнхийлөгч П. Очирбат" хэмээн сэтгэгдлээ бичиж үлдээв.

Монгол Улсын Ерөнхийлөгч тэргүүтэй төлөөлөгчид зонилсныг тохиолдуулан тус хорооны бие бүрэлдэхүүн үүндэстгэн жагсаж мэндчиллээ.

Энд болсон уулзалт дээр Ерөнхийлөгч П. Очирбат үг хэлэв. (Хэлсэн үгийг тавдугаар нүүрт нийтлэв)

Ерөнхийлөгч Монгол орны говь нутгийн нэгэн хэсгийг харуулсан уран зурагийг танкийн сургалын хороонд бэлэглэв. Батлан хамгаалахын сайд Ш. Жадамбаа Д. Сүхбаатарын хөрөг бүхий хивс дурсгал болгон үлдээлээ. Энэ хорооныхны концерт, завсэг техникийн үзэсгэлэн, гардан байлдаанд өөрийгөө хамгаалах урлагийн үзүүлэх тоглолт манай төлөөлөгчдөд өндөр сэтгэгдэл төрүүлэв.

Төлөөлөгчид хорооны сургалтын танхимууд, цэргийн байраар орж танилцлаа. Ерөнхийлөгч П. Очирбат хорооны удирдлагатай дурсгалын зураг тахууллаа. Монгол Улсын Ерөнхийлөгч П. Очирбат төгрүүтэй төлөөлөгчдийг тус хорооноос хүндэт харуул жагсаж үдэв. Владимир мужийн удирдлага Монгол Улсын Ерөнхийлөгчийг хүндэтгэн зоог барилаа.

#### 10. Бид шинэ нөхцөлд аж терж байна

Сүхбаатарын нэрэмжит, Гвардийн танкийн сургуулийн хороонд болсон уулзалт дээр Монгол Улсын Ерөнхийлөгч П. ОИЧРБАТЫН ХЭЛСЭН ҮГ

Монгол ардын хувьсгалын жолоодогч Д. Сүхбаатарын нэрэмжит, эх орны их дайны тэмцэл, тулалдаанд алдраа цуурайтуулсан Гвардийн танкийн хорооны төлөөлөгч та бүхэнтэй би анх удаа нүүр учирч уулзсандаа нэн баяртай байгаа нь шинэ уулзалт

оросын ард түмэн дэлхий дахинь анд нөхдийхөө хамт их ялалтын тавин жилийн ойт ёслол төгөлдөр тэмдагласэн баярт өдруудтэй тохиосонд оршино гэж Ерөнхийлөгч хэлэв.

П. Очирбат цааш нь Гитлерийн эсрэг эвслийн холбоотон гүрнууд фашизмын харгис хүчийг ялсны ач холбогдол болон хүн төрөлхтөн, тэр дундаас зөвлөлтийн ард түмэн энэ ялалтыг ямаршуу үнэ цэнээр байгуулсны бид бүгд өнөөдөр улам ч тод томруунаар мэдэрч байна. Зөвлөлтийн ард түмэн, зөвлөлтийн зэвсэгт хүчин л тэрхүү ялалтыг байгуулахад шийдвэрлэх үүрэг гүйцэтгэсэн билээ. Өмөхүү түүхэн үнэнийг хэн ч үгүйсгэх учиргүй. Энэ үйл явдалд аль нэг талаар хамааралтай бараг бүх улсын удирдагчид оролцож Москва хотноо хоёр өдөр тэмдэглэсэн ялалтын баярын арга хэмжээнүүд үүнийг бэлхнээ нотлон харууллаа.

Эх орны их дайны жилүүдэд зөвлөлтийн хүмүүс зориг баатирлагаар хөдөлмөрлөж гавьяа байгуулсны эдүгээ бид дахин бишрэн баходахын хамт өнгөрсөн дайчд эрэлхэгээр амь эрсдэгсдийнгэгээн дурсгалыг мэхийн хүндэтгэж байна. Тэд улс түмний эрх чөлөө, туслгаар тогтнолын телөө, дэлхийн энх амгалан, хөгжил дэвшлийн үйлсэд амь наасаа зориулсан юм. Тэдний дурсгал ариун дархан агаад тэр нь дэлхийн өнгөрсөн дайны гай гамшгийг давтахгүй байх үүднээс их үйл хийхийг улс орон бурийн цэргийн ч бай, энгийн ч бай, мөн эгэл жирийн хөдөлмөр чин, төрийн

хариуцлага хүлээлгэсэн, . хүлээлгэж ч байгаа билээ. Эл зорилт тэр тусмаа манай гаригийн яна бүрийн цэгт, тухайлбал, хуучин ЗХУ-ын нутаг дэвсгэрт, ОХУ-ын дотор ч гэсэн хүний амь насыг золиосолсон зөвсэгт мөргөлдөөн гарч буй хийгээд цэрэг дайны урьдын хямрал хэвээр байгаа нөхцөлд бүр ч чухлаар тулгарч байна. Бид дэлхийн хоёрдугаар дайны сургамжийг мартах ёсгүй. Энэ бол та бидний үүрэг. Гэхдээ ялалт байгуулснаас хойших тавин жил зөвхөн сургамж авах он жилүүд байгаагүй гэдгийг хүлээн зөвшөөрөх учиртай. "Хүйтэн дийн" хүн төрөлхтнийг юнд хүргэснийг та бид сийн мэднэ. Манай дэлхий ертөнцүү цөмийн болон үй олноор хөнөөх бусад төрлийн зөвсгийн барьцаанд байлаа. Хөгжил дэвшил, хүний сайд сайхны туслын тулд зарцуулж болох хичнээн ч нөөц боломжийг үр ашиггүй үрэн тараи хийсэн буруу огт өөр зорилгод зориулав даа ?

Ашгүй "хүйтэн дийн" здүгээ эцэс боллоо. Хоёр лагерь болж хуваагдаад байсан дэлхий ертөнцүү маань нэлээд бодит гамдрал руугаа орж, улс гүрниүүд сөргөлдөх, дайсагналцахаасаа хамтарч ажиллах, түншлэхийг илүүтэйд үзэх болж байна. Нааштай ийм хандлагыг ямар ч байсан бататгах зорилт чухал болж байна. Ийм санаа өчигдөр, уржигдар Москвад болсон баяр ёслолын арга хэмжээн дээр дэлхийн тэргүүлэх удирдагчдын хэлсэн үгэнд яруу тодорхой тусгадлаа. Түүнчлэн энх тайвныг бэхжүүлэх, их, бага бүх улсууд өөр хоорондоо хамтын ажиллагаагаа

хөгжүүлэхэд чармайлт гаргах шаардлагатайг онцлон тэмдэглэж байлаа. Харин жижиг орны ач холбогдлыг өчүүхэн ч бууруулахгүйгээр хэлэхэд ямар ч гэлээ гол үүрэг дэлхийн том гүрнүүдэд ногдоно. Үүнтэй холбогдуулан дэлхий дахины бодлогын гол төв Орос-АНУ, Орос-Варуун Европ, Орос-Хятадын түншлэл батжих шинэ үйл явц эрчээ авч байгааг сэтгэл ханамжтай тэмдэглэмээр байна. Нуур амгалан бол нугас амар гэдэг манай ардын цэцэн үг байдал. Энэ нь жижиг орон ч гэсэн дэлхий дахины улс төрийн уур амьсгалд, тухайлбал, өөрсдийнхөө эргэн тойронд нөлөөлөх учиртайг нэлээд онож хэлсэн үг гэлтэй. Энд мэдээж би дэлхий дахины үйлсийн бүхий хариуцлагыг том гүрнүүд рүү түлхэхийг огт бодоогүй юм шүү. Жижиг орнуудад ч зохих хэмжээний хариуцлага ногдох ёстой.

Монголын төр, манай засгийн газар гадаад улс төрийн бодлогынхoo чиг шугамыг тодорхойлохдос чухам энэ учир шалтгааныг удирдлага болгодог юм. Ийм учраас хөрш зэргэлдээ улсуудтай, мэдээжийн хэрэг, тэр дундаас Оросын Холбооны Улстай найрсаа харилцаагаа бэхжүүлэх, нягт хамтын ажиллагаагаа хөгжүүлэх явдал манай тэргүүлэх зорилт байдал юм.

Ер нь ч хөршүүдээ сонгодоггүй гэж ярьдаг шүү дээ. Та бид айл хөрш орших хувь тавилангаар холбогдсон улс. Монгол, Оросын ард түмэн хадэн зууны туршид эв зөийг хичээж хүнд борх үед нэг нэгэндээ тусалж дэмжсээр ирсэн билээ.

Эх орны их дайны жилүүдэд монголын ард түмэн зөвлөлтийн ард түмэнд чадал чинээнийхээ хэрээр туслан, сэтгэл Санааны дэмжлэг үзүүлий байсан нь энэхүү уламжлалын нэгэн жишээ мөн. Та бидний тэр үеийн хамтын ажиллагаа болон монгол, оросын найрамдлын бэлэг тэмдэг болсон танай Гвардийн танкийн хороо өнөөдөр ч албаа нэр төртэй гүйцэтгэж байгааг тэмдэглэхэд нэн таатай байна.

Өөр нэгэн жишээ дурдья. Маршал Георгий Константинович Жуковын хөшөөг нээх ёслолд бил оролцож цэцэг өргөлөө. Тэр хүний нэр алдар Монгол Улстай нягт холбоотой билээ. Г. К. Жуковын Гарамгай жанжны авьяас чадвар нь 1939 онд Халхын голд японы түрэмгийлэгчдийг эсэргүүцсэн тулалдаанд анх тодорсон билээ. Майай ард түмэн Монгол Улсын баатар домогт жанжин энэ хүнийг гүнээ хундэтгэдэг юм. Ийм ч учраас баярын энэ өдрүүдэд Улаанбаатар дахь Жуковын музей хүн олонтой, хажуу дахь түүний хөшөө нь цэцэг ихтэй байгаа гэв.

Та бид эдүгээшинэ нөхцөл байдалд аж төрж байна. Тус хоёр орон нийгмийн амьдралыг өрдчилах, зах зээлийн эдийн засагт шилжих адил төстэй хялбэргүй зорилтыг шийдвэрлэж байна. Энэ нь хоёр орны харилцааны шинэчлэлийг урьдчилсан тодорхойлсон юм.

Сүүлийн жилүүдэд аль аль талын чармайлтаар монгол, зөвлөлтийн харилцааны өнгөрсөн үеийг үнэлж цэгцэх, хууримтлагдсан асуудлуудыг шийдвэрлэх, монгол, оросын харилцааг цаашид

хөгжүүлэх үндэс Суурийг шинэчлэх чиглэлд чухал алхам хийгдлээ. 1993 онд намайг Орос улсад айлчлах үеэр Ерөнхийлөгч Борис Николаевич Ельцин бид хоёрын хүрсэн тохиролцооны ач холбогдлыг энд онцолж тэмдэглэмээр байна. Тэрхүү тохиролцоо хоёр орны харилцааг хөгжүүлэн гүнэгийрүүлэхэд чухал тулхэц болсон юм.

Тэр жил гарын үсэг зурсан Монгол Улс, ОХУ-ын найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай гарээ тус хоёр орны сайн хөршийн урт удаан хугацааны харилцааны улс төр, эрх зүйн үндсийг тавьсан билээ.

Манай хоёр орны харилцаа энэхүү гэрээний үзэл Санаа, агуулгын дагуу улс төр, эдийн өссөн, цэрэг, Соёлын болон бусад салбарт хойшид ч өргөжин гүнзгийрнэ гэдэгт бид итгэл төгс байна гэж Монгол Улсын Ерөнхийлөгч тэмдэглэв,

#### 11. Москвагаас мордов

Монгол Улсын Ерөнхийлөгч П. Очирбат тэргүүтэй төлөөлөгчид ялалтын 50 жилжийн сийн баярт оролцод тавдугаар сарын 11-нд эх орохдоо буцахаар Москвагаас мордов.

"Шереметьево-2" онгоцны буюудлаас төлөөлөгчдийг ОХУ-ын Онц байдлын Яамны сайд С. К. Шойгу, Гадаад явдлын Яамны орлогч сайд А.М. Панов, албан бусад хүн үдлээ.

Мөн Монгол улсаас ОХУ-д суугаа Онц бөгөөд Бүрэн

эрхт элчин сайд Н. Бавуу, ЭСЯ-ны дипломат  
ажилтнууд үдэж мордуулав.

### 12. Эх орондоо буцаж ирлээ

Монгол Улсын Ерөнхийлөгч П. Очирбат дагалдан  
аваа хүмүүсийнхээ хамт тавдугаар сарын 12-нд эх  
орондоо буцаж ирлээ. Ерөнхийлөгчийг Буюнт-Ухаагийн  
нисэх онгоцны буудал дээр Монгол Улсын Ерөнхий  
сайд П. Жасрай, Улсын Их Хурлын дэд дарга Ж.  
Ромбожав, Дэд бүтцийн хөгжлийн сайд Р. Сандалхан,  
Садаад харилцааны дэд сайд Ж. Чойнхор, Батчуул  
Чамгаалахын дэд сайд Ц. Дашзвэг нар болон албан  
бусад хүн угтав. Мөн ОХУ-аас тус улсад суугаа Онц  
богэөд Бүрэн эрхт элчин сайд С.С. Раев угталцлаа.

### 13. Москвад ялалтын баярыг ингэж тэмдэглэлээ

Би 1989 оны намар өөр улсад айлчлах замжуулж  
Москвад түр буудалласнаас хойш тэнд очоогүй юм.  
Харин энэ удаа орос нөхдийн буянаар Ялалтын 50  
жилийн ойн баярт оролцох хувь тавилан надал  
төхисолоо. Ийм завшаан дахин миний үеийнхэнд  
өлдохгүй биз. Ялалтын 100 жил ХХI зууны дунд үед  
буюу 2045 онд болно. "Ирээдүйд ахмад дайчин гэсэн

ойлголт үгүй болж, хөдөлмөрийн ахмад алдартан гэм тэмдэглэх биэээ" хэмээн нэгэн сонинд бичжээ. Үүний учир энэ түүхт баярт оролцсон тухай бодол, тэмдэглэл, эргэцүүлэл бичих үлдээхийг зорилоо.

Баяр, ёслолын арга хэмжээ  
бүхэн өөр өөр өнгөтэй байлаа

Москвад болсон Плалтын 50 жилийн ойн баяр, ёслолын арга хэмжээг сонин хэвлэл, радио, телевизээр далхийд нэгэнт цацсан учир миний хувьд бичих зүйл тун бага нь мэдээж. Гэхдээ монголчуудын соноог хүрсан, хүрээгүй гол үйл явдлаас бodoх, дурсах, эргэцүүлэх зүйл байна.

Тавдугаар сарын 8. 18 цаг.

Кремлийн ордон. Энд Дайнд оролцогчид, тэ, засгийн байгууллага, олон нийтийн нэгдлүүдийн төлөөлөгчид, зочдын баярын уулзалт боллоо.

Баярын уулзалтын тайзны засал өвермөц байв. Тайз голлуулан Яалтын одон зүүжээ. Түүний хөйр талаар хөшиг дагуулан эхэн талд нь гурван зурагс бүхий тууэн туг өлгөж дээр нь 1945 гэсэн тоо, хэлд нь шар, цагаан цэцэг, нөгөө талд нь мөн тийм байдлаар ОХУ-ын гурван өнгөт далбаан дээр 1995 гэсэн тоо, хэлд нь улаан, ягаан, хөх цэцгийн баглаа байрлуулжээ. Индрийг тайз голлуулан тавьжээ.

ОХУ-ын төр, засгийн удирдагчид, гадаадын дээд хэмжээний зочид, түүний дотор манай улсын Брөнхийлөгч П. Очирбат хурлын танхмын эхний